


УСНЫ КОМПАКТ

Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн захирал

Б.Батсүх: Үйлдвэрээ Наадмаас өмнө цахилгаан эрчим хүчинд холбох төлөвлөгөөтэй ажиллаж байна

Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрт ажиллах УСУГ-ын 27 инженер, техникийн ажилтныг 7 дугаар сарын 20-оос ажилд нь оруулна



-Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилга угсралтын ажил дуусаж, үйлдвэр ажиллаж эхлэх өдөр хаяанд иржээ. Нийт гүйцэтгэл хэдэн хувьд хүрсэн бэ. Гадаад тохижилтоо хийгээд эхэлсэн байна?

-БНТУ-ын “МАПА Иншаат ве Тиажарет” компанийн хариуцан ажиллаж байгаа Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 99.5 хувьд хүрээд байна. Одоо барилга байгууламжийн гадна тохижилт, барилга хоорондын асфальтан зам тавих, цэвэршүүлсэн ус дамжуулах шугамыг угаах, халдваргүйжүүлэх, ус хангамжийн төвлөрсөн системд (төвийн шугамд) холбох зэрэг ажил үлдсэн байгаа. Доторх тоног төхөөрөмжийн угсралтын ажил дууссан. Одоохондоо түр цахилгаантай байгаа, томоохон төхөөрөмжүүдийг холбоход хүчин чадал нь хүрэхгүй учир том төхөөрөмжүүдийн туршилт, тохируулгын ажил үлдээд байна.

-Өндөр хүчин чадалтай насос, тоног төхөөрөмжүүдийн туршилт, тохируулгаа хэзээ эхлүүлэхээр төлөвлөж байгаа вэ?

-Байнгын эрчим хүчний хангамжид холбож байж эхэлнэ. Үйлдвэр ажиллаж эхлэхэд одоо биднээс шалтгаалаад байгаа нэг том асуудал нь энэ. Энэ асуудлыг шийдүүлэхээр ажиллаж байна. Хэдхэн хоногийн өмнө холбогдох байгууллагуудтай хамтран урьдчилсан үзлэг хийлээ. ЭХЯ-аас техникийн комисс томилогдоод ирвэл Наадмаас өмнө цахилгаан эрчим хүчинд холбох төлөвлөгөөтэй байгаа. Тог цахилгаанаа түргэн холбуулчихвал гүйцэтгэгчийн зүгээс өндөр хүчин чадалтай насос, тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга хийх ажил хэвийн үргэлжлээд явах боломжтой юм.

Биокомбинатын 6 гүний худгийг эхний ээлжид ашиглалтад оруулна.

Автоматжуулсан ус түгээх байруудад хөрөнгийн тооллого, үзлэг хийв.

Geocell буюу ургамлан бүрхэвч үүсгэх замаар шороон даланг хүчитгэж нөхөн сэргээлт хийж байна.

Далайд дусал нэмэр буюу 10 мянган мод



Ус хангамжийн Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн талбай дахь барилга угсралтын ажлын газар чөлөөлөлтөд өртөх ногоон бүсийн ойн экологи-эдийн засгийн үнэлгээг “Ойн экосистемийн тогтвортой байдлыг дэмжих ногоон ой” нийгэмлэг гүйцэтгэж, Газар зүй, геоэкологийн хүрээлэнгээс мэргэжлийн дүгнэлт гаргуулсан.



ТӨСӨЛ 1. УС ХАНГАМЖИЙН БАРУУН ЭХ ҮҮСВЭРИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн хүрээнд Биокомбинат, Шувуун фабрик орчмын газрын доорх усны ордыг түшиглэн ундны усны хоёр шинэ эх үүсвэр, ус дамжуулах шугам хоолой, дэвшилтэт технологи бүхий Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулна. Төсөл хэрэгжсэнээр Улаанбаатар хотын ус хангамж жилд 50 сая орчим шоо метрээр нэмэгдэх юм.



Биокомбинатын 6 гүний худгийг эхний ээлжид ашиглалтад оруулна

- “Баран групп”-ийн ажил 75 хувийн гүйцэтгэлтэй явж байна. Төлөвлөгөөгөөр, долоодугаар сарын 20 гэхэд Биокомбинатын 6 гүний худгийг ашиглалтад оруулж, Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрт туршилт, тохируулгын усыг өгөхөөр ажиллаж байна. Бусад гүний худгуудыг барилга угсралтын хуваарьт тусгаснаар 11 дүгээр сард ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Төмөр зам доогуурх сүвлэгээний ажлын бэлтгэлийг хийж байна

- Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрт ус дамжуулах шугам хоолойн угсралтад шаардлагатай гол доогуурх болон бусад сүвлэгээний ажил дуусаж, хаалт арматур угсрах ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. Угсралтыг 10 хоногийн дотор гүйцэтгэснээр Биокомбинатын эх үүсвэрээс Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрт ус өгөхөд бэлэн болох юм. Түүнчлэн Шувуун фабрикийн талбайд гол доогуурх хамгийн урт сүвлэгээ хийх өрөмдлөгийн ажлыг эхлүүлж, төмөр зам доогуур сүвлэгээ хийх ажлын бэлтгэлийг хийж байна.

Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн захирал

Б.Батсүх: Үйлдвэрээ Наадмаас өмнө цахилгаан эрчим хүчинд холбох төлөвлөгөөтэй ажиллаж байна

Түрүүч нь 1-р нүүрт

-Үйлдвэрийг цаашид ажиллуулахад явах инженер, техникийн ажилтнуудыг бэлтгэж, сургалтад хамруулсан байгаа. Ажиллах хүчин маань одоо шинэ үйлдвэрээ ажиллуулахад бэлэн үү?

-Ажиллах хүчин бэлэн. Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрт ажиллах УСУГ-ын 27 ажилтныг 7 дугаар сарын 20-оос ажилд нь оруулах төлөвлөгөөтэй байна. Сургалт арай дуусаагүй, дараагийн шатны буюу үйлдвэр ажиллуулж эхлэх үед ахиад сургалт орно, баталгаажуулах туршилтын үед гээд 3 сарын сургалт байгаа.

-Үйлдвэрээс гарсан усаа төвийн шугамд нийлүүлэх холболтыг хэдийгээр хийх вэ?

-Энэ асуудлаар шийдэл гаргахаар нэлээд олон уулзалт хийлээ. Хотын баруун хэсэг дэх төв шугамд холбох юм л даа. Гүйцэтгэгчийн зүгээс дор хаяж 3 хоног шаардлагатай гэсэн байгаа. Тэнд орон сууцны хороолол олон, усыг нь 3 хоног хаахад хэцүү. Тиймээс УСУГ-тай байнга техникийн уулзалтууд хийж, янз янзын шийдлүүд санал болгож ярилцсаны эцэст ямартай ч 24 цаг усыг нь хаахаас өөр аргагүй болж байна. Гэхдээ эцсийн шийд гараагүй байна. Шийд гарахаар мэдэгдэл хүргүүлнэ.

Товчхон

- Биокомбинатын эх үүсвэрийн талбайд 7, Шувуун фабрикт 7 худагт насосыг нь суурилуулаад байна. Үлдсэн 16 насосыг худгийн барилгын ажилтай уялдуулан суурилуулна.
- “Баран групп”-ийн хувьд Биокомбинат, Шувуун фабрикийн эх үүсвэрийн талбайд нийт 25 орчим км шугам хоолой суурилуулахаас 24 км-ийн угсралт суурилуулалт дуусаж, 600-700 м шугам хоолойн ажил үлдээд байна.
- Шугам хоолой тавьсны дараах хучилтуудыг зэрэгцүүлэн хийж гүйцэтгэж, нөхөн сэргээх ажлыг эхлүүлээд байна.

ТӨСӨЛ 2. ХАЯГДАЛ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн хүрээнд шинэ Төв цэвэрлэх байгууламжийн дэргэд Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр ("ХУДБУ") болон дахин боловсруулсан усыг "ДЦС-3", "ДЦС-4" ТӨХК-ууд руу дамжуулах системийг барьж байгуулна. Төсөл хэрэгжсэнээр дулааны цахилгаан станцуудын техникийн усны хэрэглээний 85 хүртэл хувийг дахин боловсруулсан усаар орлуулж, гүний цэвэр усны хэрэглээг жилд 18.0 сая хүртэл шоо метрээр бууруулах юм.

Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт 88.8 хувьд хүрэв

Шинэ Төв цэвэрлэх байгууламжаас 7 дугаар сарын сүүлээр анхны усаа хүлээн авах төлөвлөгөөтэй ажиллаж байна



Шинэ Төв цэвэрлэх байгууламжаас 7 дугаар сарын сүүлээр анхны 22 мянган шоо метр хаягдал ус хүлээн авах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

*Цэвэрлэх дэд станцаас холбогдох 10кВ гадна цахилгаан хангамжийн ажлыг гүйцэтгэв.

*Шинэ Төв цэвэрлэх байгууламжид

холбогдох лаг буцаах шугамын угсралтын ажил 60%-тай үргэлжилж байна.

*Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний зааварчилгаа, сургалтын хуваарийг урьдчилсан байдлаар бэлтгэв.

100%	Хаягдал ус хүлээн авах худгийн барилга
86.7%	Шахуургын станц №1
84.0%	Тогтворжуулах сан
83.4%	Хөдөлгөөнт био реакторын байгууламж
77.6%	Ламелла тунгаагуурын байгууламж
67%	Ширхэгт дүүргэгчтэй шүүлтүүрийн барилга
90.4%	Халдваргүйжүүлэх сан
81.4%	Шахуургын станц №2
59%	Ус зайлуулах сангийн барилга
54.2%	Хлор бэлтгэлийн барилга

Тендерийн санал ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгууллаа

Хаягдал ус дахин боловсруулах төслийн хүрээнд Дахин боловсруулсан усны ашиглалт, үнэ тарифын эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, шаардлагатай нэмэлт зохицуулалтыг боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж байгаатай холбогдуулан Тендерийн санал ирүүлэхийн өмнөх уулзалтыг 2025 оны 6 дугаар сарын 4-ний өдөр цахимаар зохион байгууллаа. Уулзалтад гадаад, дотоодын 9 байгууллагын 17 төлөөлөл оролцож, зөвлөх үйлчилгээний зорилго, ач холбогдол, гүйцэтгэх ажлууд, тендер шалгаруулалтын үйл явц, тендерийн баримт бичигт заасан шаардлагыг бүрэн хангасан санал бэлтгэн ирүүлэхэд анхаарах зүйлс болон бусад дэлгэрэнгүй мэдээллийг авав.



Товчхон

- Тус тендерийн Техникийн саналыг нийтэд нээх хурлыг 6 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан бөгөөд нийт зургаан санал хүлээн авч, үнэлгээг эхлүүлээд байна.

Өргөлтийн насос станцаас "ДЦС-3" ТӨХК хүртэлх шугам хоолойг угсарч суурилуулах ажил 96.6% байна

Дахин боловсруулсан ус дамжуулах систем, ДЦС-уудын өөрчлөлтийн ажлын хүрээнд хийж гүйцэтгэж буй нийт барилга угсралтын ажил 6 дугаар сарын 30-ны байдлаар 80.72%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Үүнээс:

- Өргөлтийн насос станцаас "ДЦС-3" ТӨХК хүртэлх 500м голчтой 2 км шугам хоолойг угсарч суурилуулсан бөгөөд гүйцэтгэл 96.6% байна.
- Салаалах худгаас өргөлтийн насос станц хүртэлх 700мм голчтой шугам хоолойн ажил 72.8%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.
- Төслийн туршилт тохируулгын аргачлал, ажил гүйцэтгэх төлөвлөгөөг боловсруулаад байна.

ТӨСӨЛ 3. УСНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСӨЛ

Усны салбарын хууль эрх зүйн орчин, бодлого зохицуулалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлж, салбар байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн 5 дэд үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Автоматжуулсан 180 ус түгээх байрыг УСУГ-т хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулав



Улаанбаатар хотын 6 дүүрэгт байрлах бүрэн автоматжуулсан 180 ус түгээх байрыг УСУГ-т хүлээлгэн өгөх ажлыг амжилттай зохион байгууллаа.

Энэ хүрээнд захиалагч Монголын Мянганы сорилтын сан, гүйцэтгэгч “Эйч Ти Эл” ХХК, хүлээн авагч Ус сувгийн удирдах газар гэсэн гурван талын төлөөлөл оролцсон комисс 2025 оны 6 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд нийт 180 ус түгээх байранд очиж хөрөнгийн тооллого, үзлэг хийв. Бүрэн автоматжуулсан ус түгээх байрны удирдлагын системийн хэвийн, найдвартай ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх 24 сарын засвар үйлчилгээний гэрээг 2025 оны 5 дугаар сарын 23-нд байгуулсан бөгөөд гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.



Үнэ тариф, судалгааны газрын чадавхыг бэхжүүлэх, усны нийгмийн бодлого боловсруулах, тариф ба татаасын загвар боловсруулах гэрээг үзэглэлээ



Монголын Мянганы сорилтын сангийн Гүйцэтгэх захирал Э.Энхгэрэл болон “Ди Эйч Инфрастракчер”, “Эй Эй Ар Си Лимитед” компанийн түншлэлийг төлөөлөн Дензел Хэнкинсон нар 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо (ХСУХАТАУЗХ-Усны зохицуулах хороо)-ны Үнэ тариф, судалгааны газрын чадавхыг бэхжүүлэх, усны нийгмийн бодлого боловсруулах, тариф ба татаасын загвар боловсруулах” зөвлөх

үйлчилгээний гэрээнд гарын үсэг зурлаа.

Тус зөвлөх үйлчилгээ нь Компакт гэрээний хүрээнд хэрэгжиж буй Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн Зардал нөхөх дэд үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Мөн Усны зохицуулах хорооны Үнэ тариф, судалгааны газрын институцийн чадавхыг бэхжүүлэхийн зэрэгцээ, зорилтот бүлгийн өрхүүдэд чиглэсэн усны хүртээмжийн бодлого, татаас болон тарифын тогтолцоог сайжруулахад чиглэх юм.



Ус ашиглалтын байгууллагуудын түншлэлийн хөтөлбөрийн ээлжит сургалтад УСУГ-ын 29 инженер, техникийн ажилтан хамрагдлаа

Нидерланд Улсын ус ашиглалтын байгууллагуудын ментор, экспертүүдтэй мэдлэг солилцох долоо болон наймдугаар сургалтын аялалд УСУГ-ын 29 инженер, техникийн ажилтан хамрагдлаа. Сургалтыг 2025 оны 6 дугаар сарын 18-аас 7 дугаар сарын 1-нд

Нидерланд улсын Роттердам, Арнхем хотод зохион байгуулсан бөгөөд оролцогчид “Хөрөнгө оруулалт ба худалдан авалт”, “Орлого болоогүй ус” (Хэрэглэгчийн), “Санхүүгийн тогтвортой байдал”, “Бохир ус, ариутгах татуурга” гэсэн дөрвөн үндсэн чиглэлээр сургалт авлаа.

БАЙГАЛЬ ОРЧИН - НӨХӨН СЭРГЭЭЛТ

Барилга угсралтын ажлын төлөвлөлт, биелэлтийн бүхий л шатанд байгаль орчныг хамгаалахтай холбоотой аливаа асуудлыг Монгол Улсын холбогдох хууль эрхзүйн орчин, Олон улсын санхүүгийн корпорацын Гүйцэтгэлийн стандартад нийцүүлэн ажилладаг. Эдгээр шаардлагын дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ) Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОНННУ), Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг холбогдох төрийн байгууллагаар батлуулан дагаж мөрддөг.

Далайд дусал нэмэр буюу 10 мянган мод



Түрүүч нь 1-р нүүрт

Энэхүү судалгаагаар Ус хангамжийн Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн хүрээнд түүхий ус цуглуулах, дамжуулах шугам хоолой суурилуулах 55 км зурвас буюу голын дагуу нийт 1000 орчим ширхэг байгалийн бургас, хайлаас шууд нөлөөлөлд өртөнө гэж дүгнэсэн.

Төслийн шууд нөлөөлөлд өртөж буй эдгээр тооны мод, бургасыг хууль тогтоомжийн дагуу нөхөн тарьсан бөгөөд Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт Шувуун фабрик орчмын газрын доорх усны

ус хуримтлуулах талбайн 5.3 га газарт татмын ойн зурвас байгуулж, экосистемийн үйлчилгээг тэтгэх зорилгоор 10 мянган ширхэг бургас, улиас, хайлаас тарих ажлыг 2023 оны намрын мод тариалалтын үеэр мод үржүүлгийн мэргэжлийн байгууллага “Мөнхсоёмбо-Ундрага” ХХК хийж гүйцэтгэсэн. 2024 оны намар байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтээр ургалт 85 хувьтай гэж дүгнэсэн. Тарьсан мод, бургасыг арчилж тордон, 2025 оны 9 дүгээр сард Нийслэлийн ногоон бүсийн ойн санд хүлээлгэн өгөх юм.



Geocell буюу ургамлан бүрхэвч үүсгэх замаар шороон даланг хүчитгэх арга

Биокомбинатын эх үүсвэрээс Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр хүртэл зарим зурваст шугам хоолой суурилуулахад өндөршлийн зөрүүний улмаас газрын гадаргуу дээр дүүргэгчээр шороон далан үүсгэх шаардлага гарсан. Усархаг бороотой үед ийм далан нурах, үерт идэгдэх эрсдэлтэй учир нуралтаас хамгаалах үүднээс олон улсын практикт өргөн ашигладаг geocell бүрхэвчийг ашиглаж байна.

Үргэлжлэл 6-р нүүрт

Шувуу үргээгч

Төслийн 2021 онд батлагдсан БОННУ, биологийн олон янз байдлын үнэлгээгээр төслийн талбай орчимд нийт 6 зүйлийн шувуу ажиглагдсан нь Олон улсын байгаль хамгааллын холбооны /IUCN/ бүртгэлд нэн ховор, ховордсон зүйлүүд биш бөгөөд тархцын хувьд элбэг хэмээн бүртгэгджээ. Гэхдээ Биокомбинат, Шувуун фабрик орчим нь Туул голын сав газар учраас нүүдлийн болон бусад шувууд тааралдах магадлал өндөртэй гэж үзэн төслийн хүрээнд барьж буй цахилгаан

дамжуулах агаарын шугамаас үүдэлтэйгээр шувуу тогонд цохиулах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тулгуур болгон дээр шувуу үргээгч суулгах шаардлагатай болсон.

Практикт өргөн ашиглагддаг хуванцар, цайрдсан металл материал бүхий тольтой хос шувуу үргээгчийг Шувуун фабрикийн эх үүсвэрийн талбайн 130 тулгуурт нийт 260 ширхэг, Биокомбинат эх үүсвэрийн талбайд 145 тулгуурт нийт 290 ширхгийг тус тус суурилуулаад байна.





Geosell буюу ургамлан бүрхэвч үүсгэх замаар шороон даланг хүчитгэх арга

Түрүүч нь 5-р нүүрт

Geosell нь өндөр бат бэх полипропилен материалаар хийгдсэн гурван хэмжээст торон бүтэц бөгөөд суналт, эдэлгээ сайтай, бат бөх материал байдаг. Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн үе шат тус бүрт дүүргэгч материалыг технологийн дагуу хүчитгэн дүүргэж, ургамлын үр цацан ургамалжуулснаар geosell нь налуугийн хөрсийг нуралтаас үр дүнтэй хамгаалж, хөрсний элэгдлээс сэргийлдэг.

Одоогийн байдлаар нийт 2,5 км geosell давхарга бүхий хүчитгэсэн шороон далан байгуулаад байна.

АНУ-ын Мянганы сорилтын корпорацын Усны асуудал хариуцсан ахлах захирал Кумар Ранганатан 2025 оны 6 дугаар сарын 18-27-нд Улаанбаатар хотноо ажиллаж, Усны Компактын бүх төслийн ажил, бүтээн байгуулалтуудтай газар дээр нь очиж танилцлаа. Тэрбээр наймдугаар сарын дундуур дахин ирэхэд хэрэгжүүлсэн байх хугацаатай үүрэг чиглэл, даалгавруудыг төслийн гүйцэтгэгч нарт өгөв.

Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн нийт гүйцэтгэл

85%

